

# ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04 дүгээр  
сарын 29-ний өдөр

Дугаар 01

Улаанбаатар  
хот

Тооллогын комиссын тогтоол, хурлаас гарах  
шийдвэрүүдийг батлах тухай

Тахько (ХК) компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ НЬ:

1. Тахько (ХК) компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 01 дүгээр тогтоолыг баталсугай.
2. Тахько (ХК) компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 01 дүгээр тогтоолыг үндэслэн хурлаас гарах шийдвэрүүдийг дор дурдсанаар баталсугай. Үүнд:
  - 2.1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон 63.20 хувийн саналаар санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн батлав. удирдах зөвлөлөөс өгөх дүгнэлтийг
  - 2.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгов. Үүнд:

Ердийн гишүүнээр:

а) Жамбаагийн Чимэдцэрэнг	1,127,496	саналын эрхээр
б) Ганхуягийн Оюунгэрэлийг	1,127,496	саналын эрхээр
в) Түдэвийн Доржготовыг	967,574	саналын эрхээр
г) Лутаагийн Буянбатыг	965,235	саналын эрхээр
д) Лувсансамбуугийн Дашмягмаржавыг	964,811	саналын эрхээр
е) Даваадашийн Минжмааг	964,808	саналын эрхээр

Хараат бус гишүүнээр:

ж) Базаррагчаагийн Сийлэгмааг	1,127,496	саналын эрхээр
з) Сахъяагийн Итгэлийг	965,615	саналын эрхээр
и) Батнасангийн Бямбасүрэнг	965,600	саналын эрхээр



- 2.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын цалин, урамшууллын хэмжээг дор дурдсанаар тогтоосугай. Үүнд:
- |  |       |        |                 |
|--|-------|--------|-----------------|
| а) Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын сарын цалингийн хэмжээг 8,000,000 төгрөгөөр;                | 63.20 | хувийн | саналаар батлав |
| б) Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүний сарын цалингийн хэмжээг 1,000,000 төгрөгөөр;       | 63.20 | хувийн | саналаар батлав |
| б) Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүний сарын цалингийн хэмжээг 1,200,000 төгрөгөөр;   | 63.20 | хувийн | саналаар батлав |
| в) Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын сарын цалингийн хэмжээг 2,000,000 төгрөгөөр; | 63.20 | хувийн | саналаар батлав |
- 2.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргад олгох жилийн мөнгөн урамшууллын хэмжээг компанийн 2021 оны жилийн нийт орлогын 2.0 хүртэл хувиар;
- |  |       |        |                 |
|--|-------|--------|-----------------|
|  | 63.20 | хувийн | саналаар батлав |
|--|-------|--------|-----------------|
- 2.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн дотоод ажлын жилийн зардлын төсөв (цалин, урамшууллыг оролцуулахгүйгээр)-ийг 9,450,000 төгрөгөөр;
- |  |       |        |                 |
|--|-------|--------|-----------------|
|  | 63.20 | хувийн | саналаар батлав |
|--|-------|--------|-----------------|

ХУРЛЫН ДАРГА



Л.БУЯНБАТ

# ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04 дүгээр  
сарын 29-ний өдөр

Дугаар 02

Улаанбаатар  
хот

Компанийн 2021 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн  
тайлангийн талаарх дүгнэлтийг батлах тухай

Тахько (ХК) компанийн 2021 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн  
тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг Тооллогын комиссын  
2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 01 дүгээр тогтоолыг үндэслэн ТОГТООХ  
НЬ:

1. Компанийн 2021 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн  
талаарх Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгөх дүгнэлтийг зөвшөөрч баталсугай.
2. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн  
удирдах зөвлөлийн дүгнэлтэд дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлж ажиллахыг  
шинээр сонгогдсон Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Л.БУЯНБАТ

# ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04 дүгээр  
сарын 29-ний өдөр

Дугаар 03

Улаанбаатар  
хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдсоныг баталж,  
бүрэн эрхийг зөвшөөрөх тухай

Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, Компанийн дүрмийн 7.2.4 дэх заалт, Тооллогын комиссын 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

Дор дурдсан хүмүүсийг Тахько (ХК) компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнээр сонгогдсоныг баталж, тэдгээрийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсүгэй. Үүнд:

Ердийн гишүүнээр:

Лутаагийн Буянбат  
Лувсансамбуугийн Дашмягмаржав  
Түдэвийн Доржготов  
Даваадашийн Минжмаа  
Ганхуягийн Оюунгэрэл  
Жамбаагийн Чимэдцэрэн

Хараат бус гишүүнээр:

Батнасангийн Бямбасүрэн  
Сахъяагийн Итгэл  
Базаррагчаагийн Сийлэгмаа

ХУРЛЫН ДАРГА



Л.БУЯНБАТ

# ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04 дүгээр  
сарын 29-ний өдөр

Дугаар 04

Улаанбаатар  
хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын сарын цалин, жилийн мөнгөн урамшууллын хэмжээг тогтоож, дотоод ажлын зардлыг батлах тухай

Тахько (ХК) компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын Тооллогын комиссын 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 01 дүгээр тогтоолыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын сарын цалингийн хэмжээг 8,000,000 төгрөгөөр, ердийн гишүүний сарын цалингийн хэмжээг 1,000,000 төгрөгөөр, хараат бус гишүүний сарын цалингийн хэмжээг 1,200,000 төгрөгөөр, нарийн бичгийн даргын сарын цалингийн хэмжээг 2,000,000 төгрөгөөр тус тус тогтоосугай.
2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргад олгох жилийн мөнгөн урамшууллын хэмжээг компанийн 2022 оны жилийн нийт орлогын 2.0 хүртэл хувиар тогтоосугай.
3. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дотоод ажлын зардлын төсөв (цалин, урамшууллыг оролцуулахгүйгээр)-ийг 9,450,000 (Есөн сая дөрвөн зуун тавин мянга) төгрөгөөр баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Л.БУЯНБАТ